

Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгааны тайлан



МӨНГӨНИЙ БОДЛОГО, СУДАЛГААНЫ ГАЗАР СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

Танилцсан:

Ерөнхийлөгч

Л.Пүрэвдорж

Хянасан:

МБСГ-ын захирал

Д.Болдбаатар

СХ-ийн захирал

Н.Амар

Боловсруулсан:

СХ-ийн эдийн засагч

Д.Энхзаяа

СХ-ийн дадлагажигч ажилтан

Д.Даваасүх

СХ-ийн дадлагажигч ажилтан


Л.Дөлгөөн

ХУРААНГУЙ

Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгааг 2012 оны 6-р сард Улаанбаатар хотын 1013 иргэд, 432 аж ахуй нэгж болон 12 шинжээчдийг хамруулан явууллаа.

Иргэд инфляци 2012 оны 3-р улиралд **16.2%**, жилийн эцэст **17.8%**, 2013 оны эхний хагаст **17.6%** болно гэж хүлээж байна. Инфляцийн хүлээлтийн ерөнхий хандлагыг чиглэлийн индекс тооцон харахад иргэдийн хүлээлт өсөх хандлагатай байгаа ч “одоогийнхтой ойролцоо түвшинд өснө” гэсэн мужид харгалзаж байна. Инфляцийн түвшин өсөх хүлээлттэй холбоотойгоор ирэх жилд өрхийн санхүүгийн байдал сайжирна гэж хариулсан иргэдийн хувь өмнөх судалгаатай харьцуулахад буурсан байна. Харин өрхийн санхүүгийн байдал сайжирна гэж үзэж байгаа иргэдийн дийлэнх нь цалин, бизнесийн орлого өснө, үл хөдлөх хөрөнгийн үнэ өснө, өрхийн гишүүд ажлын байртай болно гэсэн хүлээлттэй байна.

Зураг 1. Иргэд, аж ахуйн нэгж болон судлаачдын инфляцийн хүлээлт



Будагдсан хэсэг иргэд, ААН-ийн хүлээгдэж буй инфляцийн түвшин болон судлаачдын таамаглалыг илтгэнэ.

Аж ахуйн нэгж, байгууллагууд инфляцийн түвшинг 2012 оны 3-р улиралд **13.8%**, жилийн эцэст **12.9%**, 2013 оны 2-р улиралд **13.1%** болно гэсэн хүлээлттэй байна. Өөрөөр хэлбэл, түүхий эд материалаалын үнийн түвшин оны эцэс хүртэл буурах хүлээлттэй байгаа бөгөөд эдийн засгийн өсөлттэй уялдан аж ахуйн нэгжүүдийн 47% нь ирэх 6 сард үйл ажиллагаагаа өргөжүүлэх төлөвлөгөөтэй байна. Тэдгээрийн 47% нь өөрийн хөрөнгөөр санхүүжих бол 44% нь банкны зээлээр санхүүжих сонирхолтой байна. Үүнээс үйлчилгээний салбар, бөөний болон жижиглэн худалдааны салбарт банкны зээлийн эрэлт илүү нэмэгдэх хандлагатай байна. Түүнчлэн аж ахуйн нэгжүүд ажлын байрыг 30 хүртэлх хувиар нэмэгдүүлэхийн зэрэгцээ цалингийн түвшинг 14 хүртэлх хувиар нэмэгдүүлэх төлөвтэй байна.

Шинжээчдийн таамаглалаар инфляци 2012 оны 3-р улирлаас жилийн эцэст хүртэл тогтмол **16.6%**, 2013 оны эхний хагас жилд буурч **14.3%** болно гэж таамаглаж байна. Төгрөгийн ам доллар болон юаньтай харьцах ханш 2012 оны 3-р улирал хүртэл суларч, 4-р улирлаас эхлэн чангарна гэж таамаглаж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт улирлын нөлөөллөөр 1 ба 3 улирлуудад бага зэрэг буурах ч ерөнхий хандлага нь өсөхөөр төсөөлж байна. Мөн нэрлэсэн цалинг тогтвортой өснө гэж таамаглаж байна.

1. ХЭРЭГЛЭГЧДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Түүвэр судалгаанд Улаанбаатар хотын 9 дүүргийн 135 хорооноос 1013 иргэдийг санамсаргүй түүврийн аргачлалаар сонгож хамрууллаа. Судалгааны зарим үр дүнгээс дурдахад иргэд инфляци 3 сарын дараа **16.2%**, хагас жилийн дараа **17.8%**, жилийн дараа **17.6%** болж, одоогийн инфляцийн түвшингээс өсөхөөр хүлээж байна. Мөн үнийн өсөлтийг тодорхой тоон заагуудаас асуухад иргэд инфляци жилийн дараа дунджаар **11.4%** болно гэж үзжээ.

СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

- Судалгаанд оролцогчдын 56.1% нь эмэгтэй;
- Насны бүтцийг харвал 55.0% нь 25-44 насны;
- Боловсролын түвшингээр авч үзвэл 85.8% нь бүрэн дунд болон дээд боловсролтой;
- Ам бүлийн тоог харвал 84.8% нь 2-5 ам бүлтэй;
- Ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл 52.7% нь хувийн салбарт ажилладаг, 15.2% нь төрийн албанд, 22.2% нь ажилгүй;
- Өрхийн орлогын зүгээс харвал 52.1% нь 200-600 мянган төгрөгийн орлоготой, 6.7% нь 200 мянгаас бага, 41.2% нь 600 мянган төгрөгөөс дээш орлоготой өрхүүд байлаа.

1.1 ХҮЛЭЭЛТИЙН ЕРӨНХИЙ ХАНДЛАГА


Зураг 1.1 Жилийн инфляцийн хүлээлтийн чиглэлийн индекс



Чиглэлийн индекс нь иргэдийн инфляцийн хүлээлтийн хандлагыг харуулах бөгөөд индексийн утга ихсэх нь хүлээлтийн түвшин өсч байгааг, эсрэгээрээ хүлээлт буурч байгааг илтгэнэ. Харин индексийн утга 2 гэсэн хязгаарын шугамыг давбал хүлээлтийн түвшин хэт өндөр байгааг харуулна. **Зураг 1.1**-ээс харахад иргэдийн хүлээлт 2011 оны 1, 6-р сарууд болон 2012 оны 1-р сард хамгийн өндөр түвшиндээ хүрч иргэдийн дунд “инфляци одоогийнхоос хурдан өснө” гэж үзэх хандлага давамгайлсан байна. Бусад үеүүдэд болон сүүлийн судалгааны дүнгээр иргэд “инфляци одоогийн түвшиндээ байна” гэж үзэх хандлагатай болжээ. Энэ нь хүлээлт өмнөх судалгааны дүнгээс бага зэрэг өссөн мэт харагдаж байгаа хэдий ч одоогийн инфляцийн түвшин хоёр оронтой тоонд¹ байгаа нь хүлээлт харьцангуй өндөр байгааг харуулж байна.


¹ 2012 оны 5-р сард Улаанбаатар хотын инфляци 16.6% байна.

Зураг 1.2: Ирэх 12 сарын хугацаанд үнийн түвшин хэрхэн өөрчлөгдөх вэ?



Хүлээлтийн чанарын хариултаас харвал иргэдийн 91.7% нь ирэх 12 сард үнийн түвшин ерөнхийдөө өснө гэж үзсэн бөгөөд үүнээс 60.8% нь *үнийн түвшин хурдацтайгаар өснө* гэж хариулжээ /Зураг 1.2/.

Зураг 1.3: Инфляци, мэдрэгдсэн инфляци



ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТООН УТГА

Иргэдийн өгсөн чанарын хариултуудыг ашиглан Карлсон-Паркин² нарын магадлалын аргаар хүлээгдэж буй инфляцийн түвшинг объектив болон субъектив хандлагаар тооцооллоо. Өнгөрсөн хугацааны *мэдрэгдсэн инфляцийн түвшинг* суурь болгон инфляцийн хүлээлтийг тооцоолохыг **субъектив хүлээлт** гэдэг бол одоогийн инфляцийн түвшинг суурь болгон тооцоолохыг **объектив хүлээлт** гэнэ.

Зураг 1.4: Жилийн инфляцийн хүлээлт (объектив, субъектив)




Иргэдэд мэдрэгдсэн инфляцийн түвшин хугацааны туршид буурах хандлагатай байсан бөгөөд тус судалгааны дүнгээр мэдрэгдсэн инфляцийн түвшин 8.8% гарсан байна /Зураг 1.3/.


Объектив хүлээлт нь сүүлийн судалгааны дүнгээр 17.6% буюу иргэд жилийн дараа инфляци одоогийн түвшнээсээ бага зэрэг өснө гэж үзсэн байна. Харин субъектив аргачлалаар тооцоолсон хүлээлт нь иргэдийн мэдрэсэн инфляцийн түвшнээс өсч 10.1% байхаар хүлээгдэж байна. Объектив, субъектив хүлээлтийн зөрүүтэй байдал нь мэдрэсэн инфляци болон одоогийн инфляцийн зөрүүтэй байдлаар тайлбарлагдах юм. /Зураг 1.4/

² Carlson, John A. and Parkin, Michael /1975/: Inflation expectations. "Economica" 42, pp. 123-38.


Зураг 1.5: Хүлээлтийн түвшин, тоон хариулт (ирэх 12 сарын хугацаанд)



Зураг 1.6: Иргэдийн 12 сарын дараах хүлээлтийн харьцуулалт



Зураг 1.7: Таны бодлоор ирэх 12 сарын хугацаанд банкны зээлийн хүү хэрхэн өөрчлөгдөх вэ?



1.3 ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТООН ХАРИУЛТ

Иргэдийн 12 сарын дараах хүлээлтийн түвшинг тодорхой тоон завсраас асуух замаар тооцоолол хийлээ. Зураг 1.5-аас харахад судалгаанд оролцсон иргэдийн 23% нь инфляцийг 12 сарын дараа 9-11%-д, 11% нь 7-9%-д, 10% нь 5-7%-д, 23% нь 11-13% байна гэж үзжээ. Иргэдийн тоон хариултуудын дундаж утгаар 12 сарын дараа инфляци **11.4%** байна гэж хүлээж байна.


1.4 ХҮЛЭЭЛТИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Иргэдийн улирлын хүлээлтийн тоон утгуудыг харьцуулан харвал хагас жилийн эцсээр субъектив хүлээлт 9.1% хүрсэн бол объектив хүлээлтийн дүн 16.2% -тай байна /Зураг 1.6/. Харин 6 сарын дараа буюу 12-р сарын эцсээр субъектив хүлээлт буурч 20%, объектив хүлээлтийн дүн 17.8% байна. Жилийн хүлээлтийн түвшинг харвал объектив хүлээлт 17.6% байхад субъектив хүлээлтийн түвшин огцом буурч 10.1% болсон байна. Иргэдээс авсан тоон утгыг харвал жилийн дараа инфляци 11.4% болно гэж хариулжээ.

1.5 БУСАД АСУУЛТУУДЫН ХАРИУЛТ


Судалгаанд оролцогчдын 33.6% нь ирэх 12 сарын хугацаанд зээлийн хүү өснө гэж үзсэн нь өмнөх судалгааны дүнгээс 5.8 нэгжээр буурсан хэдий ч бусад судалгаануудын дүнгүүдтэй харьцуулахад өндөр хэвээр байна /Зураг 1.7/. Харин өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад зээлийн хүү хэвэндээ байна гэсэн хариулт бага зэрэг өсч, хүү буурна гэсэн хариулт 8.1 нэгжээр өссөн дүнтэй гарсан байна.

Зураг 1.8: Таны бодлоор ирэх 12 сард төгрөгийн ханш хэрхэн өөрчлөгдөх вэ?




Судалгаанд оролцсон иргэдийн 26.3% нь ирэх нэг жилд төгрөгийн ханш чангарна гэж үзсэн нь өмнөх судалгаануудтай харьцуулахад харьцангуй бага түвшиндээ хүрэв. Харин төгрөгийн ханш суларна гэж үзсэн иргэдийн хувь өмнөхөөс огцом өссөн боловч бусад судалгааны дүнгүүдтэй харьцуулбал өндөр хэвээр байна /Зураг 1.8/. Иргэдийн төгрөгийн ханшийн хүлээлтийн чиглэлийн индексийг харвал энэ удаагийн судалгааны дүнгээр ханш суларна гэсэн хүлээлттэй гарлаа.

Зураг 1.9: Таны бодлоор ирэх 12 сард хадгаламжинд мөнгө хийхэд тохиромжтой үе мөн үү?



Судалгаанд оролцогчдын 33.4% нь ирэх 12 сарын хугацаанд хадгаламжид мөнгөө байршуулахгүй гэж хариулсан байна. Харин мөнгөө хадгаламжинд байршуулах иргэдийн хувь 2.2 нэгжээр өсч 27.4%-д хүрчээ /Зураг 1.9/.

Зураг 1.10: Танай өрхийн санхүүгийн байдал ирэх 12 сарын хугацаанд хэрхэн өөрчлөгдөх вэ?




Ирэх 12 сарын хугацаанд иргэдийн өрхийн санхүүгийн байдал сайжирна гэж судалгаанд оролцогчдын 34.6% хариулсан нь өмнөх судалгааны дүнгээс 5.6 нэгжээр буурсан дүнтэй байна. Харин хэвэндээ байна, муудна гэсэн хариултуудын хувь өмнөх судалгаанаас 3.5 нэгжээр өсч 49.1%-д хүрсэн бөгөөд үүнээс муудна гэсэн хариултын хувь 10.4%-д хүрчээ /Зураг 1.10/.

Зураг 1.11: Өрхийн санхүүгийн байдлын талаарх хүлээлтийн чиглэлийн индекс




2008 оны эцэст хийгдсэн судалгааны дүнгээр иргэдийн дийлэнх нь ирэх 12 сарын хугацаанд өрхийн санхүүгийн байдал муудна гэж үзсэн бол 2009 оны 9-р сараас хойш хийгдсэн судалгаануудаар сайжирна гэсэн хандлага давамгайлах болсон. Чиглэлийн индекс 2012 оны 3-р сарын судалгааны дүнгээр өмнөхөөс өссөн ч энэ удаагийн судалгаагаар 0.06 нэгжийн бууралттай гарлаа. Өмнөх судалгаануудын дүнгээс харахад хүлээлт буурсан үеүдэд инфляцийн түвшин үргэлж 2 оронтой тоонд орсон байхад, хүлээлт сайжирсан үед инфляци харьцангуй доогуур түвшинд байв. Энэ удаагийн судалгааны дүнгээр инфляци харьцангуй өндөр ч хүлээлт буурчээ /Зураг 1.11/.

Зураг 1.12: Сайжрах бол шалтгаан нь юу вэ?



Өрхийн санхүүгийн байдал сайжирна гэж судалгаанд оролцсон иргэдийн 34.6% нь хариулсан бөгөөд тэдгээрийн 50.8% нь ирэх 12 сард цалин болон бизнесийн орлого нэмэгдэнэ гэж үзсэн байна. Мөн 8.5% нь үл хөдлөх хөрөнгийн үнэ өснө гэж хариулсан нь иргэдийн эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ өсч, түүнээсээ орлого олно гэж үзсэн байна. Үүнээс гадна иргэдийн 14.2% нь өрхийн гишүүн шинээр ажлын байртай болно гэжээ /Зураг 1.12/.

Зураг 1.13: Муудах бол шалтгаан нь юу вэ?



Өрхийн санхүүгийн байдал муудна гэж иргэдийн 10.5% нь хариулсан бөгөөд тэдгээрийн 26.7% нь ирэх 12 сарын хугацаанд үнэ өссөнөөс шалтгаалан өрхийн санхүүгийн байдал муудна гэж үзжээ. Харин 30.8% нь цалин болон бизнесийн орлого буурна, 12% өрхийн гишүүн ажилгүй болно, 7% нь татварын ачаалал ихэснэ гэж үзжээ /Зураг 1.123/.

ДҮГНЭЛТ

Инфляцийн хүлээлтийн ерөнхий хандлага буюу чиглэлийн индекс өсч “инфляци одоогийн түвшиндээ байна” гэсэн мужид байна. Инфляцийн хүлээлтийн объектив хандлагыг жишиг болгон мөрдөх нь тохиромжтой бөгөөд хүлээлт 1 улирлын дараа одоогийн түвшнээс өсч 16.2% орчимд, 6 сарын дараа 17.8% орчимд байхаар хүлээж байгаа бол жилийн дараа 17.6% орчимд байна гэж хүлээж байна. Бусад асуултуудын дүнгээр иргэдийн дийлэнхи нь ирэх 12 сарын хугацаанд зээлийн хүү өсч, төгрөгийн ханш суларна гэж үзсэн байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад иргэдийн төгрөгт итгэх итгэл бага зэрэг буурсан нь ажиглагдаж байна.

Ирэх жилд өрхийн санхүүгийн байдал сайжирна гэж үзсэн иргэдийн хувь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад буурсан байгаа ч бусад судалгааны дүнгээс өндөр бөгөөд тэдгээрийн дийлэнхи нь цалин, бизнесийн орлого өснө, үл хөдлөх хөрөнгийн үнэ өснө, өрхийн гишүүд ажлын байртай болно гэсэн хүлээлттэй байна. Харин арван хүн тутмын нэг нь өрхийн санхүү муудна гэснээс ихэнхи нь үнэ өсч, цалин болон бизнесийн орлого муудна гэсэн байна. Иргэдийн дийлэнх нь ирэх 12 сарын хугацаанд хадгаламжинд мөнгө хийхэд тохиромжгүй гэж үзсэн хэвээр байна.

2. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДЫН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ДҮН

Аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд явуулсан инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаанд Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй нийт 432 аж ахуйн нэгжийг хамрууллаа. Судалгааны үр дүнг нэгтгэхэд аж ахуйн нэгж, байгууллагууд 2012 оны III улиралд инфляцийн түвшинг **13.8%**, 2012 оны IV улиралд **12.9%**, харин 2013 оны II улиралд **13.1%**-д хүрнэ гэсэн хүлээлттэй байна.

Хүснэгт 2.1 Аж ахуйн нэгж /өмчлөлөөр/		
Аж ахуйн нэгжийн хэлбэр	тоо	хувь
Нөхөрлөл	15	3.5%
Хоршоо	7	1.6%
Хувьцаат компани	7	1.6%
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	402	93.1%
Төрийн өмчийн үйлдвэрийн газар	1	0.2%
Нийт дүн	432	100.0%

2.1. ТҮҮВЭР СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИД

Судалгаанд хамрагдсан нийт 432 аж ахуй нэгж, байгууллагуудыг өмчлөлийнх хэлбэрээр авч үзвэл ихэнхи буюу 93.1% (402) нь хязгаарлагдмал хариуцлагатай хувьцаат компани, 3.5% (15) нь нөхөрлөл, 3.2% (14) нь хоршоо болон хувьцаат компаниуд байна. /Хүснэгт 2.1/

Хүснэгт 2.2 ААН-ийн үйлдвэрлэл, үйлчилгээ /салбараар/		
Салбарын бүлэг	тоо	хувь
Хөдөө аж ахуй	3	0.7%
Уул уурхай, олборлох	14	3.2%
Боловсруулах үйлдвэр	3	0.7%
Барилга	25	5.8%
Бөөний болон жижиглэнгийн худалдаа	80	18.5%
Жижиг дунд үйлдвэрлэл	37	8.6%
Үйлчилгээ	255	59.0%
Тээвэр	15	3.5%
Нийт дүн	432	100.0%

Үйлчилгээ эрхэлдэг 255 (59.0%), бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг 80 (18.5%), жижиг дунд үйлдвэрлэл эрхэлж буй 37 (8.6%), барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг 25 (5.8%), тээврийн үйлчилгээ эрхэлдэг 15 (3.5%), уул уурхай, олборлох болон хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй 14 (3.2%), 3 (0.7%) аж ахуйн нэгжийг тус тус хамрууллаа /Хүснэгт 2.2/


Хүснэгт 2.3 ААН-ийн салбарын бүлэг /ажилчдын тоогоор/					
Салбарын бүлэг	Ажилчдын тоо /бүлгээр/				
	< 10	11–50	51–100	101 <	Бүгд
Хөдөө аж ахуй	1	2	0	0	3
Уул уурхай, олборлох	3	9	1	1	14
Боловсруулах үйлдвэр	0	1	0	2	3
Барилга	2	12	6	5	25
Б/Ж-ийн худалдаа	57	15	4	4	80
Жижиг, дунд үйлдвэрлэл	19	12	5	1	37
Үйлчилгээ	193	53	4	5	255
Тээвэр	10	5	0	0	15
Нийт дүн	285	109	20	18	432

Түүвэр судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагаа эрхэлж буй салбар болон ажилчдын бүлгээр авч үзвэл 10 хүртэлх ажилчидтай аж ахуйн нэгжүүд 66% (285), 11-50 хүртэлх ажилчидтай компаниуд 25.2% (109), 51-100 хүртэлх ажилчидтай 4.6% (20), 101-с дээш ажилчидтай ААН-үүд нийт судалгаанд оролцогчдын 4.2% (18)-г эзэлж байна. Харин 10 хүртэлх ажилчидтай үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхэлж буй компаниуд дийлэнх буюу 44.7%-г эзэлж байгаа бол тус тооны ажилчидтай бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлж буй аж ахуй, нэгжүүд 13.2% (57) -г эзэлж байна. /Хүснэгт 2.3/

2.2 ҮНИЙН ЕРӨНХИЙ ТҮВШИН ИЙ ХҮЛЭЭЛТ

Аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд явуулсан 2012 оны II улирлын инфляцийн хүлээлтийн санал асуулгыг явуулахдаа чанарын болон тоон хариултыг авах замаар 2 аргачлалын хүрээнд хүлээлтийг тооцсон болно.


Зураг 2.1 ААН-ийн инфляцийн хүлээлтийн чанарын хариулт



ҮНИЙН ЕРӨНХИЙ ТҮВШИН /чанарын хариулт/

“Танай компанийн түүхий эд болон бусад бараа материалд төлж байгаа үнэ ирэх 12 сард хэрхэн өөрчлөгдөнө гэж та үзэж байна вэ?” - Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгааны үндсэн асуулт болох дээрх асуултанд судалгаанд оролцсон нийт аж ахуйн нэгж, байгууллагуудын 62.7% нь үнийн түвшин ерөнхийдөө өснө гэсэн нь өмнөх судалгааны дүнгээс 2.6 нэгж хувиар өссөн байна. Үүнд үнэ хурдацтай өснө буюу инфляци өснө гэж хариулсан ААН, байгууллагууд 19.7% буюу өмнөх судалгааны дүнгээс 1.2 нэгж хувиар өссөн, үнэ өснө гэхдээ хурдац өөрчлөгдөхгүй гэж 33.3% буюу өмнөх үеэс 10 нэгж хувиар өссөн ба өсөлтийн хурдац буурна гэж 9.7% нь хариулсан бол 2.1% нь үнэ буурна гэж хариулжээ. /Зураг 2.1/

Зураг 2.2 ААН-ийн инфляцийн хүлээлтийн чиглэлийн индекс




Санамж: Чиглэлийн индекс нь (-1;3) завсарт утгаа авна. Нэмэх чиглэл руу хүлээлтийн хандлага өссөн, хасах чиглэл руу инфляцийн хүлээлтийн хандлага буурсан байгааг илтгэнэ.

Чиглэлийн индексээс харахад 12 сарын дараах үнийн хүлээлт 2012 оны 1-р сар буюу өмнөх судалгааны дүнгээс 1.60 болж өссөн аж ахуйн нэгжүүд инфляци өснө гэсэн ерөнхий хүлээлттэй байна. /Зураг 2.2/.

Чанарын хариултыг Карлсон-Паркины аргачлал (Carlson-Parkin method)-аар тоон үзүүлэлт рүү шилжүүлэн тооцоход аж ахуйн нэгж, байгууллагын түүхий эд болон бусад бараа материал, үйлчилгээнд төлж байгаа хүлээгдэж буй инфляцийн түвшин 2012 оны III улиралд **13.8%**, 2012 оны IV улиралд **12.9%** байна гэсэн бол 2013 оны II улиралд инфляци **13.1%** гэж хүлээгдэж байна.

Зураг 2.3 ААН-ийн 12 сарын дараах үнийн өсөлтийн түвшин /харьцангуй давтамж/




ҮНИЙН ЕРӨНХИЙ ТҮВШИН /тоон хариулт/

Түүвэр судалгаанд оролцсон нийт аж ахуйн нэгж, байгууллагуудын 12 сарын дараах инфляцийн хүлээлтийн түвшинг тоон интервалиар тодорхойлох замаар санал асуулгыг авч үр дүнг нэгтгэхэд 12 сарын дараах хүлээгдэж буй инфляцийн түвшин **10.3%**-тай байна. /Зураг 2.3/.

2.3. БУСАД ХАРИУЛТ


Зураг 2.4 ААН-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээний өнгөрсөн 6 сар дахь эрэлт




БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРЭЛТ

Судалгаанд оролцсон нийт аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн болон үйлчилгээний өнгөрсөн 6 сарын хугацаандах эрэлтийн хувьд санал асуулгад оролцогчдын 42.6% нь өссөн, 40.5% нь өөрчлөгдөөгүй, 16.9% нь буурсан гэж хариулсан нь өмнөх оны мөн үеийн судалгааны дүнтэй харьцуулахад эрэлт өссөн гэсэн хариултын хувь 4.2 нэгж хувиар өсч, харин эрэлт буурсан гэсэн хариулт 0.7 нэгж хувиар буурсан нь иргэдийн худалдан авалт өмнөх хоёр улиралд нэмэгдсэнийг илтгэж байна. /Зураг 2.4/


Зураг 2.5 ААН-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээний ирэх 6 сарын эрэлт




Харин аж ахуйн нэгж, байгууллагуудын ирэх 6 сарын хугацаанд бүтээгдэхүүн болон үйлчилгээний хүлээгдэж буй эрэлтийн хувьд 46.8% нь өснө, 26.2% нь өөрчлөгдөхгүй, 10.9% нь буурна гэж хүлээж байна. Эрэлт өснө гэсэн хариулт өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 6.9 нэгж хувиар нэмэгдсэн нь эдийн засгийн өсөлттэй уялдан ихэнхи аж ахуйн нэгжүүд өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтийг цаашид өснө гэсэн хүлээлттэй байж болох юм. Харин өөрчлөгдөхгүй гэсэн хариулт 3 нэгж хувиар буурсан бол мэдэхгүй гэсэн хариулт 3.8 нэгж хувиар өссөн байгаа нь аж ахуйн нэгжүүд ирээдүйн бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлтийн өөрчлөлтийн талаархи таамаглал байхгүй байгааг илэрхийлж байна. /Зураг 2.5/

Зураг 2.6 ААН байгууллагуудын ажлын байр ирэх 6 сард

Санамж: 2009 оны 3,9-р сарын судалгаанд ирэх 3 сарын талаар асуусан болно

Зураг 2.7 ААН байгууллагуудын цалин ирэх 6 сард

Санамж: 2009 оны 3,9-р сарын судалгаанд ирэх 3 сарын талаар асуусан болно

Зураг 2.8 ААН байгууллагуудын ирэх 6 сардахь цалингийн дундаж өсөлт

Санамж: 2009 оны 3,9-р сарын судалгаанд ирэх 3 сарын талаар асуусан болно

Хүснэгт 2.4 ААН-ийн ажлын байр, цалингийн өсөлт

Ирэх сард ажилчдын тоо хэрхэн өөрчлөгдөх вэ?	Ирэх 6 Сард цалингаа өсгөх үү?		
	Тийм	Үгүй	Нийт дүн
Нэмэгдэнэ	22.5%	13.0%	35.4%
Өөрчлөгдөхгүй	17.8%	43.3%	61.1%
Буурна	0.7%	2.8%	3.5%
Нийт дүн	41.0%	59.0%	100.0%

АЖИЛ ЭРХЛЭЛТ, ЦАЛИН


Судалгаанд оролцогч ААН, байгууллагуудын ирэх 6 сарын ажлын байрны өөрчлөлтийн хувьд судалгаанд оролцогчдын 35.4% нь нэмэгдэнэ гэж хариулсан нь 2012 оны 1-р сарын судалгааны дүнгээс 1.7 нэгж хувиар буурсан бол ажилчдын тоо өөрчлөгдөхгүй гэж 61.1%, буурна гэж 3.5% нь хариулжээ. Үүнээс үзэхэд ирэх 6 сард ажлын байр бага зэрэг нэмэгдэх хандлагатай байна. /Зураг 2.6/

Ирэх 6 сард судалгаанд хамрагдсан нийт ААН, байгууллагуудын 41% цалингаа нэмнэ гэсэн бол үлсэн 59% нь өөрчлөхгүй гэж хариулжээ. Энэ нь 2012 оны 1-р сарын дүнгээс нэмэгдүүлнэ гэсэн нь 8.3 нэгж хувиар буурсан, өөрчлөгдөхгүй гэсэн нь мөн 8.3 нэгж хувиар өссөн байгаа нь ирэх 6 сард цалингаа нэмэгдүүлэх аж ахуйн нэгжийн тоо буурахыг харуулж байна. /Зураг 2.7/

Нийт судалгаанд оролцогч ААН-үүдийн ирэх 6 сард цалингийн түвшингээ нэмэгдүүлэх аж ахуйн нэгжүүд цалингийн түвшингээ дунджаар 14.9%-иар нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байгаа нь өмнөх судалгааны дүнгээс 1 нэгж хувиар буурсан байна. /Зураг 2.8/

Түүнчлэн ажлын байрны тоогоо нэмэгдүүлж, ирэх 6 сард цалингаа нэмэгдүүлэхээр төлөвлөж буй ААН-үүд нийт судалгаанд оролцогчдын 22.5% нь байгаа бол ажлын байрны тоонд өөрчлөлт оруулахгүйгээр ирэх 6 сард цалингаа нэмэхээр төлөвлөж буй ААН-үүд 17.8%-ийг тус тус эзэлж байгаа бол ажлын байрны тоог бууруулсанаар ажилчидынхаа цалинг нэмэгдүүлэх хүсэлтэй ААН-үүд маш бага буюу 0.7%-ийг эзэлж байна. Харин цалингаа нэмэгдүүлэхгүйгээр ажлын байрыг нэмэгдүүлэх, өөрчлөхгүй байх, бууруулах хүсэлтэй компаниуд харгалзан 13%, 43.3%, 2.8%-иудыг тус тус эзэлж байна. /Хүснэгт 2.4/


Зураг 2.9 ААН-ийн санхүүжилт авах эх үүсвэр



Хүснэгт 2.6 ААН-үүдийн санхүүжилт авах эх үүсвэр үйл ажиллагаа эрхэлдэг салбараар

Салбарын бүтэг	Санхүүжилтийн хэлбэр						Нийт дүн
	Банкны санхүүжилтээр	Компаны өөрийн хөрөнгөөр	Хувьцаа гаргах	Гадаад эх үүсвэрээр	Санхүүгийн байгууллагын эх үүсвэрээр	Тэтгэлэг тусламжаар	
Хөдөө аж ахуй	0.4%	0.4%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.9%
Уул уурхай, олборлох	1.7%	3.0%	0.4%	0.4%	0.0%	0.0%	5.6%
Боловсруулах үйлдвэр	0.0%	0.9%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.9%
Барилга	2.2%	4.7%	0.4%	0.0%	0.4%	0.0%	7.8%
Б/Ж-ийн худалдаа	12.5%	11.2%	0.0%	0.0%	0.4%	0.0%	24.1%
Жижиг, дунд үйлдвэрлэл	6.9%	3.9%	0.0%	0.4%	0.0%	0.4%	11.6%
Үйлчилгээ	20.3%	21.6%	0.4%	1.7%	1.7%	0.9%	46.6%
Тээвэр	0.9%	1.3%	0.0%	0.0%	0.4%	0.0%	2.6%
Нийт дүн	44.8%	47.0%	1.3%	2.6%	3.0%	1.3%	100.0%

Хүснэгт 2.10 ААН-ийн ирэх 6 сарын зээлийн хэрэгцээ




САНХҮҮЖИЛТ БОЛОН ЗЭЭЛ

Санал асуулгад оролцсон ААН, байгууллагуудын 47.7% нь ирэх 6 сарын хугацаанд компаниа өргөжүүлэх төлөвлөгөөтэй байгаа бол үлдсэн 52.3% нь үгүй гэж хариулсан байна. Өргөжүүлэх төлөвлөгөөтэй байгаа ААН, байгууллагуудын хувьд 44.8% нь банкны санхүүжилтээр, 47.0% нь компанийн өөрийн хөрөнгөөр санхүүжинэ гэсэн бол гадаад эх үүсвэр, хувьцаа гаргах, бусад санхүүгийн байгууллагын эх үүсвэрээр, тэтгэлэг тусламжаар санхүүжих ААН-үүд үлдсэн 8.2%-ийг эзэлж байна. /Зураг 2.9/

Өргөжилт хийхээр төлөвлөж буй ААН-үүдийг үйл ажиллагаа эрхэлж буй салбараар авч үзвэл үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниуд хамгийн их банкны зээлээр санхүүжих хандлагатай байгаа буюу судалгаанд оролцогчдын 20.3%-ийг, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгчид 12.5%-ийг тус тус эзэлж байгаа бол үйлчилгээний болон бөөний, жижиглэнгийн худалдаа эрхлэгчид өөрийн хөрөнгөөр санхүүжилт авах компаниудын дийлэнхийг буюу 21.6%, 11.2%-г тус тус эзэлж байна. Түүнчлэн хувьцаа гаргаж эх үүсвэр татахаар төлөвлөж буй уул уулхай олборлох болон барилгын салбарын ААН-үүд тус бүр 0.4%-ийг эзэлж байна. /Хүснэгт 2.5/

Нийт судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн хувьд ирэх 6 сард зээлийн хэрэгцээ нэмэгдэнэ гэж 32.6% нь хариулсан бол өөрчлөгдөхгүй гэж 59.3% нь, 8.1% нь буурна гэж хариулсан байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад ирэх 6 сард зээлийн хэрэгцээ бага зэрэг буурч байна. Харин буурна гэсэн хариулт өмнөх судалгааны дүнгээс 2.9 нэгж хувиар өссөн байгаа нь ирэх 6 сард зээлийн хэрэгцээ өмнөх судалгааны дүн болон өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурах хандлагатай байна. /Зураг 2.10/

Зураг 2.11 ААН-ийн ханшийн түвшний хүлээлт



ХАНШИЙН ХҮЛЭЭЛТ

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдээс төгрөгийн бусад валютуудтай харьцах ханшийн хүлээлтийг тодруулахад 3, 6, 12 сарын дараа төгрөгийн ханш суларна гэж судалгаанд оролцогчдын 49.3%, 47.2%, 47.7% нь тус тус хариулсан нь аж ахуйн нэгжүүдийн ихэнх нь ханш суларна гэсэн хүлээлттэй байгааг харуулж байна. /Зураг 2.11/

ДҮГНЭЛТ

Инфляцийн хүлээлтийн санал асуулгын дүнгээр судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагууд инфляцийн түвшинг 2012 оны III улиралд **13.8%**, 2012 оны жилийн эцэст **12.9%**, 2013 оны II улиралд **13.1%** болно гэсэн хүлээлттэй байна. Өөрөөр хэлбэл аж ахуйн нэгжүүд инфляцийн түвшин оны эхний хагасаас эхлэн жилийн эцэс хүртэл буурч, цаашид бага зэрэг өснө гэсэн хүлээлттэй байна.


Ажиллах хүчний зах зээлд дараагийн 6 сард ажлын байр 30 хүртэлх хувиар нэмэгдэх хандлагатай бөгөөд ирэх 6 сард ажилчдынхаа цалин хөлсийг нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байгаа аж ахуйн нэгжийн тоо 41 хүртэлх хувиар нэмэгдэхээр байна. Түүнчлэн үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр төлөвлөж буй аж ахуйн нэгж байгууллагын тоо ирэх 6 сарын хугацаанд 47 хүртэлх хувиар нэмэгдэх төлөвтэй байна. Тус ААН-үүдэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийн 47 хүртэлх хувь нь өөрийн хөрөнгөөр, 44 хүртэлх хувь нь банкнаас санхүүжих сонирхолтой байна. Үүнээс дийлэнх нь үйлчилгээний, бөөний болон жижиглэн худалдаа эрхлэгчид байна. Мөн ирэх 6 сард ААН-үүдийн 32 хүртэлх хувь нь банкны зээлийн эрэлтийг нэмэгдүүлэхээр байна. Судалгаанд оролцсон ААН-үүдийн 20 хүртэлх хувь нь төгрөгийн ханш цаашдаа чангарна гэж үзэж байгаа бол 47 хүртэлх хувь нь төгрөгийн бусад валюттай харьцах ханш суларна гэсэн хүлээлттэй байна.

3. ШИНЖЭЭЧДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР

СУДАЛГААНЫ ДҮН

Шинжээчдийн инфляцийн хүлээлтийн судалгаанд арилжааны банк, хөгжлийн банк, их сургууль болон судалгааны төвд ажилладаг нийт 12 шинжээч оролцов. Уг санал асуулгад эдийн засгийн гол үзүүлэлтүүд (инфляци, нийт мөнгөний өсөлт, төгрөгийн ханш, ДНБ-ий өсөлт, цалин)-ийг багтаасан бөгөөд хариултыг шууд тоон үзүүлэлтээр авч, шинжээчдийн таамгуудын жигнэсэн дунджаар хүлээлтийг тооцоолов. Судалгааны дүнгээс харахад шинжээчид жилийн инфляци 2012 оны 2-р улиралд 16.8%, оны эцэст 16.6%, 2013 оны эхний хагас жилд 14.3% болохоор тус тус таамаглаж байна. Тус санал асуулгыг 2012 оны II улирлын инфляци болон бусад үзүүлэлтүүдийн албан тоон мэдээлэл зарлагдахаас өмнө явуулсан тул шинжээчдийн таамаглалыг 2012 оны II улирлаас эхлэн харуулсан болно.

Зураг 3.1 Инфляци




Эх сурвалж: Монголбанк

Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийн харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

3.1. ИНФЛЯЦИ

Шинжээчдийн таамгаар жилийн инфляци 2012 оны 2-р улиралд 16.8%, 3 ба 4-р улиралд 16.6% байхаар тус тус хүлээгдэж байна. Харин 2013 оноос эхлэн инфляци 2 нэгж хувиар буурч, 1-р улиралд 14.2%, 2-р улиралд 14.3% байхаар таамаглажээ. Өмнөх судалгаатай харьцуулахад 2012 оны инфляцийн хүлээлт 3.5 орчим нэгж хувиар өссөн байна. Шинжээчдийн таамгаас харахад хамгийн өндөр хүлээлттэй нь оны эцэст 22.6%, хамгийн бага хүлээлттэй нь 2013 оны 1-р улиралд 9.8% болохоор таамаглажээ /Зураг 3.1/.

Зураг 3.2 Нийт мөнгөний өсөлт /M2/




Эх сурвалж: Монголбанк

Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

3.2. НИЙТ МӨНГӨНИЙ ӨСӨЛТ /M2/

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2012 оны сүүлийн хагасаас 2013 оны эхний хагас хүртэл 29-32% хооронд байхаар таамаглаж байна. Энэ удаагийн шинжээчдийн таамаглалыг өмнөх судалгаатай харьцуулахад дунджаар 14.0 орчим нэгж хувиар буурсан дүнтэй байна. Шинжээчдийн таамгаас харахад хамгийн өндөр хүлээлттэй нь 2012 оны эцэст M2 мөнгөний жилийн өсөлт 53.2%, хамгийн бага хүлээлттэй нь 14.2% байхаар тус тус таамаглажээ /Зураг 3.2/.

Зураг 3.3 Төгрөг/долларын ханш




Эх сурвалж: Монголбанк

Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

3.3. ТӨГРӨГИЙН АМ.ДОЛЛАРТАЙ ХАРЬЦАХ ХАНШ

Шинжээчид төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш 2012 оны 3-р улирал хүртэл суларч 1351.3 төгрөгт хүрэх бөгөөд 4-р улирлаас чангарч эхлэн 2013 оны 2-р улиралд 1308.9 төгрөг болохоор төсөөлж байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 2012 оны эцсийн ханшийн хүлээлт 4.4 хувиар суларсан байна. Шинжээчдийн таамгаас харахад хамгийн өндөр хүлээлттэй нь 2013 оны 1-р улиралд төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш 1445.5 төгрөг, хамгийн бага хүлээлттэй нь 1261.4 төгрөг байхаар тус тус таамаглаж байна. /Зураг 3.3/.

Зураг 3.4 Төгрөг/юаны ханш




Эх сурвалж: Монголбанк

Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

3.4. Төгрөгийн юаньтай харьцах ханш

Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш 2012 оны 3-р улирал хүртэл бага зэрэг сулрах бөгөөд 4-р улирлаас эхлэн чангарч, оны эцэст 213.4 төгрөг, 2013 оны 2-р улиралд 204.4 төгрөг байхаар хүлээгдэж байна. Өмнөх судалгаатай харьцуулахад оны эцсийн юаны ханшийн хүлээлт 5.7%-иар өссөн байна. Шинжээчдийн таамгаас хамгийн өндөр хүлээлттэй нь 2013 оны 1-р улиралд юанийн ханш 241.1 төгрөг, хамгийн бага хүлээлттэй нь 199.6 төгрөг байхаар тус тус тооцоолжээ /Зураг 3.4/.

Зураг 3.5 ДНБ-ий жилийн өсөлт




Эх сурвалж: Монголбанк

Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

3.5. ДНБ-ий жилийн өсөлт

ДНБ-ий өсөлт 2012 оны сүүлийн хагасаас 2013 оны эхний хагас хүртэл дунджаар 16-18%-ийн хооронд өсөлттэй байхаар таамаглаж байна. Энэ нь өмнөх судалгаатай харьцуулахад 3 ба 4-р улирлын таамаглал харгалзан 3.9 ба 2.0 нэгж хувиар буурчээ. Шинжээчдийн таамгаас харахад хамгийн өндөр хүлээлттэй нь 2013 оны 2-р улиралд ДНБ-ий өсөлт 27.2%, хамгийн бага хүлээлттэй нь 2012 оны 2-р улиралд 11.0% болохоор тус тус таамаглажээ /Зураг 3.5/.

Зураг 3.6 Сарын дундаж нэрлэсэн цалин



Эх сурвалж: Монголбанк

Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

3.6. САРЫН ДУНДАЖ НЭРЛЭСЭН ЦАЛИН

Шинжээчдийн таамгаар сарын дундаж нэрлэсэн цалин оны эцэст 577.0 мянган төгрөг, 2013 оны эхний хагаст 623.6 мянган төгрөгт хүрч одоогийн түвшнээс 25.8%-иар өснө гэж тооцоолж байна. Өмнөх судалгаатай харьцуулахад шинжээчдийн цалингийн хүлээлт бараг хэвээрээ байна. Шинжээчдийн таамгаас харахад хамгийн өндөр хүлээлттэй нь 2013 оны 2-р улиралд сарын дундаж нэрлэсэн цалин 770.0 мянган төгрөг, хамгийн бага хүлээлттэй 520.0 мянган төгрөг байхаар тус тус таамаглажээ /Зураг 3.6/.

ДҮГНЭЛТ

Шинжээчдийн таамгаас харахад инфляци 2012 оны сүүлийн хагаст харьцангуй тогтвортой, 2013 онд бага зэрэг буурах хүлээлттэй байна. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2012 оны 3-р улирлаас эхлэн аажмаар нэмэгдэх таамагтай байна. ДНБ-ий өсөлт 1 ба 3-р улиралд бага зэрэг буурах ч ерөнхий хандлага нь өсөхөөр таамаглаж байна. Төгрөгийн ам.доллартай харьцах болон юаньтай харьцах нэрлэсэн ханш 2012 оны 3-р улирал хүртэл суларч, 4-р улирлаас хойш чангарах төсөөлөлтэй байна. Нэрлэсэн цалин тогтвортой өсөхөөр таамаглаж байна.